

**ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-4

1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Засгийн газарт чиглэл өгөх тухай/ 3-4

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны
11 дүгээр сарын 01-ний өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга Б.Баттөмөр ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 10 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 22 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Бейсен;

Чөлөөтэй: Б.Баярсайхан, С.Бямбацогт, Б.Энхбаяр.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Засгийн газарт чиглэл өгөх тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш байлцав.

Байнгын хорооны дарга Б.Баттөмөр “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд үг хэлэв.

Б.Баттөмөр: “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 3
Бүгд: 6
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Баттөмөр: Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 2
Бүгд: 6
66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Баттөмөр: “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 2
Бүгд: 6
66.7 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 15 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 09 минут үргэлжилж, ирвэл зохих 10 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр 15 цаг 31 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.БАТТӨМӨР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
15 цаг 22 минут.

ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Баттөмөр: Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгаж мэндчилье. Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амар амгаланг эрж мэндчилье. Өнөөдөр Ёс зүйн байнгын хорооны гишүүдийн олонх бүрэлдсэн ирсэн тул Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр хуралдаан 10-ны, 11 дүгээр сарын 01-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Хуралдаанд ирсэн гишүүдийг танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Адьшаа ирсэн байна, Улсын Их Хурлын гишүүн Баделхан ирсэн байна, Улсын Их Хурлын гишүүн Энх-Амгалан байна, Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд байна, Улсын Их Хурлын гишүүн Баттөмөр байна. Хуралд одоо ирээгүй байгаа Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр, Сандагийн Бямбацогт ирээгүй байна. Баярсайхан гишүүн ирж байна, одоо ороод ирнэ. Гишүүд, ирээгүй байгаа гишүүд хуралдаандаа орохыг хүсье. Ирцийг танилцуулж дууслаа.

Хэлэлцэх асуудал Байнгын хорооны тогтоолын төсөл Засгийн газарт чиглэл өгөх тухай. Энэ тогтоолын төслийг бол Байнгын хорооны сайтад байрлуулчихсан байгаа. Та бүгдэд нөгөө шилээр бас тараачихсан байгаа. Болно, болно. Тэгээд энэ бол Монгол Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооноос санаачилсан Шинжлэх ухааны академи Философийн хүрээлэн, Монгол Улсын Их

сургуулийн Шинжлэх ухааны Философи, шаашин судлалын танхимтай хамтран зохион байгуулсан Өнөөгийн Монголын нийгмийн ёс суртахууны өөрчлөлт, хандлага гэсэн сэдвээр төрийн байгууллага, олон нийтэд хандлага гаргасан зөвлөмж, уриалгыг үндэслэн байнгын хорооны тогтоолоор Засгийн газарт чиглэл өгөх тухай юм. Ингээд хэлэлцэх асуудалдаа, хэлэлцэх асуудалтай холбогдуулан өөр саналтай гишүүн байна? Алга байна. Тэгье энэ, Энхболд гишүүн. Энхболд гишүүнд микрофон өгье.

Н.Энхболд: Байнгын хорооны тогтоолын төсөлтэй танилцсан, дэмжиж байгаа. Ер нь өнөөдөр манай нийгэмд зөвхөн төрийн албанд ч гэлтгүй нийгэмд тулгарч байгаа хамгийн том асуудлын нэг бол үнэхээр одоо энэ ёс зүй, ёс суртахуунтай холбоотой асуудал байгаа. Бүх л муу юмны эх үүсвэр, бүүр доороос нь эхлээд яривал гэр бүлийн хүмүүжил, хүмүүсийн боловсрол, хүн байх эсэх тухай асуудлаар бид нар хүн болгож хүмүүжүүлэх талаар, хүмүүжүүлэх талаар ер нь их шүүмжлэлтэй хандахад юм хийхгүй шахуу олон жил явж ирсний үр дагавар болж ингэж нийгэм даяараа ёс суртахууны асуудал, ёс зүйн асуудал их хурц тавигдахад хүрээд байна. Тэгээд энэ чиглэлээр манай Байнгын хорооноос санаачилж ийм Засгийн газарт чиглэл өгөхөөр тогтоол гаргаж явуулж байгааг дэмжиж байгаа.

Ялангуяа энэ дотор төрийн албан хаагчидтай холбоотой Засгийн газраас гүйцэтгэх засаглалын зүгээс ёс суртахууны шалгуурыг өндөрсгөх, төрийн албанд тавих шаардлагыг өндөрсгөх, төрийн албанд томилогдох, тушаал дэвшүүлэхдээ тэр хүн урьд нь ямар нэгэн байдлаар ёс зүйн шаардлага, ёс зүйн хэм хэмжээг зөрчиж байсан бол тийм хүмүүсийг дэвшүүлдэггүй, томилдоггүй байх зарчмыг баримтлах талаар гэх мэтчилэн ийм чиглэлүүд өгсөн ийм тогтоол болж байгаа юм.

Зүгээр энэ завшааныг ашиглаад Баттөмөр даргаа нэг юм би хэлчихье. Манай Байнгын хороо Төрийн албаны хуульд заасны дагуу Ёс зүйн хорооны гишүүдийг томилоод явж байгаа цуваад тийм ээ, 3 хүнээ томилчихсон, одоо 1 үлдчихсэн байгаа. Тэгээд энэ завшааныг ашиглаад бас одоо нэг хүний орон тоо сул байж байгаа, орон тооны бус гишүүний. 6 гэхэд энд нэрээ дэвшүүлэх хүмүүс материалаа ирүүлэх ёстой. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр зар сурталчилгаа нэлээн явж байгаа байх. Тэгээд энэ Ёс зүйн хороо бол өөрөө маш том үүрэгтэй, хуулиар олгогдчихсон эрхтэй. Төрийн албанд ёс зүйг төлөвшүүлэх, шаардлагуудыг нь өндөрсүүлэх талаар олон чухал ажил хийх нэлээн том эрхтэй ийм байгууллага байгаа юм. Тэгэхээр энд бас л түрүүчийн шалгаруулалтаар нэлээн олон хүн саналаа ирүүлээд, зарим нь янз бүрийн шатанд тэнцэлгүй явсан. Тэгэхээр би бас энэ ёс зүйн асуудалд анхаарал тавьдаг, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулъя гэж боддог мэргэисэн тэр шаардлагад нийцсэн ийм нөхцөл болзол хангасан хүмүүс байгаа болбол 6-нд багтаад энэ Ёс зүйн хороонд материалаа ирүүлээд энэ сонгон шалгаруулалтад оролцохыг бас зарлаж байна гэх нь хаашаа юм уриалж байна. Маш чухал ажил байгаа. Онцгой чухал ач холбогдолтой ийм хороо. нэлээн өндөр шалгууртай энийг бас хүмүүст нь анхаараарай гэж хэлэх гэсэн юм.

Б.Баттөмөр: Нямаагийн Энхболд гишүүнд баярлалаа. Энэ Ёс зүйн хороо, Ёс зүйн хорооны орон тооны бус 1 гишүүнд болбол нэр дэвшүүлэх ажил одоо өрнөж байгаа. Манай Байнгын хорооны ажлын албанаас энийг мэдээллийн хэрэгслээр маш сайн зарлах хэрэгтэй. Энэ дээр бас нэлээн олон хүмүүс орж, тодорхой шалгууртай, шалгуурын үндсэн дээр ингээд 1 хүн томилогдоно. Ингэснээрээ Төрийн албаны зөвлөлийн Ёс зүйн хороо бол бүрэн бүрэлдэхүүнээр ажиллах ийм боломж бүрдэх юм байгаа юм. Ийм учраас бүх сувгаар энэ зарлалыг бол сайн явуулах хэрэгтэй гэж ингэж үзэж байгаа.

Энэ Байнгын хорооны тогтоолын төслийг цахимаар тараачихсан байгаа, дээрээс нь цаасаар тараачихсан байгаа. Ер нь Их Хурлын гишүүд бол нэлээн саналаа өгсөн. Ялангуяа манай Нямаагийн Энхболд гишүүн энэ дээр бол маш их сайн ажиллаж, бидний гаргасан юун дээр бол бас зөв зарчмын зүйтэй хэд хэдэн саналуудыг энд оруулж ирж, засваруудыг хийж өгсөнд Энхболд даргад бол баярлаж байна. Манай Адьшаа гишүүн бол энэ дээр бас сайн ажиллаж бас бас санал онолоо бол хэлсэн. Баделхан гишүүн бол бас санал онолоо хэлсэн. Бусад гишүүд ч гэсэн бас санал онолоо хэлсэн. Би энийг уншиж танилцуулах уу, хэрэггүй юу? Тэгээд үг, асуулт 2 хамт явж байгаа. Сая Нямаагийн Энхболд гишүүн санал хэлчихлээ. Өөр гишүүд саналтай гишүүн байна уу? Ингээд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Ингээд санал хураалт явуулъя. Байнгын хорооны энэ хаана байна вэ, нөгөөдөх чинь. Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Уучлаарай миний энэ уг нь ажилласангүй. Энэ саяын санал хураалтыг бол хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураалт хураая. 66,7 хувийн саналаар санал дэмжигдэж байна. Дахиад санал хураалт явуулна. Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Байнгын хорооны тогтоолын төсөл 66,7 хувийн саналаар дэмжигдэж байна. Ингээд хуралдаа идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа. Хурлаар хэлэлцэх асуудал дууслаа. Баярлалаа.

15.31 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА

